



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Замын-Үүдийн дулааны станц ТӨҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2024/01/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Ахлах аудитор: О.Нарангарав Аудитор: М.Дүүрэнжаргал Цахим хаяг: duurenjargalm@audit.gov.mn	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Цахим хаяг: narangaravo@audit.gov.mn
---	---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2024.03.15 № 1-6/287

танай _____ -ны № _____ -т

“ЗАМЫН-ҮҮДИЙН ДУЛААНЫ
СТАНЦ” ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ
О.ТӨМӨРХУЯГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Замын-Үүдийн дулааны станц ТӨҮГ-ын оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Замын-Үүдийн дулааны станц ТӨҮГ-ын оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус газрын санхүүгийн үндсэн үзүүлэлт нь болох нийт орлого төлөвлөгөөнөөс 896.3 сая төгрөгөөр буюу 12.5 хувиар тасарсан, нийт зардал 634.9 сая төгрөгөөр буюу 7.1 хувиар хэтэрсэн гүйцэтгэлтэй, нийт алдагдал 1,531.2 сая төгрөгөөр давсан зэрэг нь тайлант оны дэвшүүлсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилгод түвшинд хүрээгүй байна. Энэ нь тайлант оны дулааны борлуулалтыг дутуу хийсэн, эргэлтийн бус хөрөнгийн элэгдлийн зардлыг дутуу тооцсон, гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнэ өссөн зэрэг үзүүлэлт голчлон нөлөөлсөн байна.

Аудитын гол асуудал

- Санхүүгийн тайланд тусгагдсан авлагаас 15 харилцагч байгууллагын нийт 50.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.
- Тус газрын үндсэн хөрөнгийг түүвэрлэн биет тооллогын горим хэрэгжүүлэхэд 12-66 УХТ улсын дугаартай TOYOTO Ланд Круйсер Прадо маркийн суудлын автомашиныг байгууллагын бүртгэлд туснаагүй байна.

010079316

3. Тайлан онд нийт 818.6 сая төгрөгийн 51 орлогын гүйлгээ, 392.7 сая төгрөгийн 19 зарлагын гүйлгээ болон 556.4 сая 63 тушаал, шийдвэрийг хуулийн хугацаанд байршуулаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд худалдан авах ажиллагааны журмын дагуу орон нутгаас зарласан дэд бүтцийн ажил гүйцэтгэх 226.6 сая төгрөгийн тендерт оролцож 116.0 сая төгрөгийг гүйцэтгэлийн санхүүжилтээр авч, үлдэгдэл санхүүжилтийг дараа онд ажлыг гүйцэтгэж дуусган авахаар гэрээг байгуулсан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,167,520,028.07	202,374,495.32
1.1.02	Дансны авлага	419,866,819.76	531,340,254.73
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	10,046,296.33	9,938,206.60
1.1.04	Бусад авлага	30,954,093.30	66,311,448.49
1.1.06	Бараа материал	969,669,243.79	937,059,358.88
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	37,306,184.74	26,276,246.08
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,635,362,665.99	1,773,300,010.10
1.2.01	Үндсэн хөрөнгө	71,475,468,507.78	70,117,562,848.03
1.2.02	Биет бус хөрөнгө	24,986,370.23	20,728,189.40
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	71,500,454,878.01	70,138,291,037.43
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	74,135,817,544.00	71,911,591,047.53
2.1.1.01	Дансны өглөг	5,913,296.12	574,476,489.49
2.1.1.03	Татварын өр	20,453,144.78	72,925,364.22
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	2,200,000.00	35,833,646.28
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	3,876,775.57	3,626,129.37
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	32,443,216.47	686,861,629.36
2.2	Өр төлбөрийн нийт дүн	32,443,216.47	686,861,629.36
2.3.01	Өмч: - төрийн	75,256,227,787.78	75,567,469,417.78
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	19,112,120.17	106,632,845.92
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-1,171,965,580.42	-4,449,372,845.53
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	-3,307,132,355.72
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-1,171,965,580.42	-1,142,240,489.81
2.3.11	Эздийн өмчийн дүн	74,103,374,327.53	71,224,729,418.17
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	74,135,817,544.00	71,911,591,047.53

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	4,986,026,012.27	6,252,154,129.49
02	Борлуулалтын өртөг	5,934,921,374.32	8,227,102,073.95
03	Нийт ашиг(алдагдал)	-948,895,362.05	-1,974,947,944.46
04	Түрээсийн орлого	31,818.18	1,070,435.00
05	Хүүний орлого	26,849,315.07	6,933,177.06
08	Бусад орлого	636,363,636.36	252,768.88
08.1	Орлогын дүн	663,244,769.61	8,256,380.94
10	Ерөнхий ба удирдлагын зардал	806,894,716.40	1,294,341,389.21
11	Санхүүгийн зардал	427,215.68	434,500.00
12	Бусад зардал	3,580,367.35	44,971,585.29
12.1	Зардлын дүн	810,902,299.43	1,339,747,474.50
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	-1,096,552,891.89	-3,306,439,038.02
19	Орлогын татварын зардал	0.00	693,317.70
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-1,096,552,891.89	-3,307,132,355.72
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-1,096,552,891.89	-3,307,132,355.72

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2021 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	58,447,078,331.66	0.00	-28,333,744.29	58,418,744,587.37
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	-47,078,944.24	-47,078,944.24
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	-1,096,552,891.89	-1,096,552,891.89
06	Өмчид гарсан өөрчлөлт	16,809,149,456.12	0.00	0.00	16,809,149,456.12
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	19,112,120.17	0.00	19,112,120.17
09	2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	75,256,227,787.78	19,112,120.17	-1,171,965,580.42	74,103,374,327.53
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	29,725,090.61	29,725,090.61
11	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	-3,307,132,355.72	-3,307,132,355.72
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00
14	Өмчид гарсан өөрчлөлт	311,241,630.00	0.00	0.00	311,241,630.00
15	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	87,520,725.75	0.00	87,520,725.75
17	2023 оны 12 сарын 31-р үлдэгдэл	75,567,469,417.78	106,632,845.92	-4,449,372,845.53	71,224,729,418.17

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,771,641,960.85	6,864,722,108.88
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	5,493,274,885.08	6,764,399,034.15
1.1.6	Бусад мөнгөн орлого	578,367,075.77	100,323,074.73
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,992,032,232.32	7,605,747,496.63
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,817,755,777.80	2,970,684,495.14
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	588,647,132.35	923,679,711.24
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,641,204,865.67	1,516,124,922.60
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	382,971,048.95	663,160,099.58
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	249,789,610.00	379,534,740.78
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	709,553,804.00	842,189,227.62
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	2,411,981.00	3,909,311.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	596,117,645.20	306,464,988.67
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	779,609,728.53	-741,025,387.75
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	232,410,272.73	224,120,145.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	219,683,000.01	224,120,145.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-232,410,272.73	-224,120,145.00
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	547,199,455.80	-965,145,532.75
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	620,320,572.27	1,167,520,028.07
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,167,520,028.07	202,374,495.32

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 оны	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	<i>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт :</i>				
1	а/ Дулаан үйлдвэрлэлт	мян.Гкал	59,900.0	79,000.0	63,340.0
	б/Үнийн дүнгээр	мян.төг			
	Нийт орлого	мян.төг	5,649,270,700.0	7,156,746,200.0	6,260,410,509.0
	Үүнээс: Цэвэр борлуулалт	мян.төг	4,372,163,400.0	6,643,092,100.0	5,832,041,942.0
2	в/ Бусад орлого /алданги торгуулийн засвар үйлчилгээний орлогууд/	мян.төг	640,743,700.0	513,654,100.0	428,368,567.0
	Нийт зардал	мян.төг	6,745,823,670.0	8,932,605,300.0	9,567,542,864.0
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	79,603,000.0	236,293,000.0	212,139,338.0
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	(1,096,552,970.0)	(1,775,859,100.0)	(3,307,132,355.0)
	Улсын төсвийн санхүүжилт		636,363,640.0		
5	Цэвэр ашиг, алдагдал	мян.төг	(460,189,330.0)	(1,775,859,100.0)	(3,307,132,355.0)
	Төсвийн төлбөрт нийт дүн	мян.төг	1,030,472,590.0	1,205,470,360.0	1,744,942,000.0
	а/Орлогын татварт	мян.төг			
	б/Нэмэгдсэн өртгийн татвар	мян.төг	339,468,600.0	315,840,000.0	341,248,400.0
	в/НДШ	мян.төг	327,197,800.0	477,121,000.0	923,755,100.0
	г/Хүн амын орлогын татвар	мян.төг	195,913,550.0	238,589,000.0	298,138,300.0
	д/Үл хөдлөх хөрөнгийн татвар	мян.төг	157,200,000.0	161,090,260.0	155,084,100.0
	е/Газрын төлбөр	мян.төг	440,000.0	3,160,000.0	2,955,310.0
	ё/Тээврийн хэрэгслийн татвар	мян.төг	1,900,000.0	721,100.0	822,900.0
	ж/Ус ашигласны татвар	мян.төг	5,652,640.0	5,849,000.0	3,393,170.0
	з/Агаарын бохирдол	мян.төг	900,000.0	900,000.0	1,561,400.0
	з/Бусад татвар	мян.төг	1,800,000.0	2,200,000.0	17,983,320.0
7	Төрийн өмчийн ногдол ашигт	мян.төг			
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	141.0	146.0	135.0
9	Нийт цалингийн сан	мян.төг	2,057,117,800.0	3,290,489,500.0	3,205,097,039.0
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	мян.төг	1,215,790.0	1,945,330.0	1,978,455.0
12	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төгрөг	1.19	1.25	1.53
13	Хөрөнгө оруулалт	мян.төг	126,100,700.0	393,813,000.0	207,440,400.0
14	Нийт авлага	мян.төг	460,867,140.0	418,000,000.0	607,589,900.0
	Үүнээс:Найдаргүй				
	Нийт өглөг	мян.төг	32,443,210.0		647,401,800.0
	Үүнээс: Богоино хугацаат	мян.төг	1,040,030.0		647,401,800.0
	Үүнээс: Урт хугацаат өр төлбөр	мян.төг			

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа илрээгүй бөгөөд үнийн дүнгүй нийт 3 зөрчил илэрч, 3 зөвлөмж өгсөн.

3.1. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Санхүүгийн тайланд тусгагдсан авлагаас 15 харилцагч байгууллагын нийт 50.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Ерөнхий нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэгтэй” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланд тусгагдсан авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ажиллах

2. Хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Тайлан онд нийт 818.6 сая төгрөгийн 51 орлогын гүйлгээ, 392.7 сая төгрөгийн 19 зарлагын гүйлгээ болон 556.4 сая 63 тушаал, шийдвэрийг хуулийн хугацаанд байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ.. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ...бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7-т “цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт”, 8.4.8-т “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг байнга ил тод, нээлттэй байлгана” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж, шилэн дансны системд мэдээллийг хугацаанд нь байршуулах

3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус газрын үндсэн хөрөнгийг түүвэрлэн биет тооллогын горим хэрэгжүүлэхэд 2003 онд үйлдвэрлэсэн 12-66 УХТ улсын дугаартай ТООТОО Ланд Круйсер Прадо маркийн суудлын автомашиныг байгууллагын бүртгэлд тусгаагүй байна. Уг хөрөнгийг эзэмшүүлэх гэрээг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай 2021 онд байгуулсан боловч 2022 оны 5 дугаар сарын 19-ны өдрөөр дуусгавар болсон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэг, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна” , 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ”, 20

дугаар зүйлийн 20.2.6-т “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагад ашиглагдаж буй тээврийн хэрэгслийг эзэмших хүсэлтийг холбогдох байгууллагад хүргүүлэх эсхүл хөрөнгийг шилжүүлэх зэргээр үндсэн хөрөнгийг шийдвэрлэх арга хэмжээ зохион байгуулах

Дээрх үндсэн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 08 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох
ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
-												
-												
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо
Үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна	1	-					1	-					
Авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна	1	-					1	-					
Дүн	2	-					2	-					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны системд мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан	1	-						1	-
Дүн	1	-	-	-	-	-	-	1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	1	-	-	-	-	-	-	1	-

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	ТБОНӨБ	1	1			1			
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			